



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн
загвар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан загварыг удирдлага болгон ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлэхийг хадгаламж, зээлийн хоршоодод зөвлөсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



ДБАЯРСАЙХАН

1518000010

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн
02 дугаар тушаалын хавсралт



ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү ёс зүйн дүрмийн зорилго нь Хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны гишүүн, Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, Зээлийн хорооны гишүүн /цаашид “сонгуульт гишүүн” гэх/ болон гүйцэтгэх захирал, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“ХЗХ-ны эрх ашиг” гэж ХЗХ-ны бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дүрэм, журам, шийдвэрт нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

1.2.2.“хувийн ашиг сонирхол” гэж албан үүргээ гүйцэтгэхдээ өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

1.2.3.“давуу байдал” гэж нэр төр, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

ХОЁР. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ

2.1.ХЗХ-ны гишүүн, сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь ажил, үүрэг гүйцэтгэхдээ Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан үйл ажиллагааны зарчмаас гадна дараах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг баримтлан ажиллана. Үүнд:

2.1.1. холбогдох хууль тогтоомж, ХЗХ-ны дүрэм, журам, гэрээ, шийдвэрийг чанд мөрдөнө;

2.1.2. үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулна;

2.1.3. бусад оролцогч талуудын эрхийг хүндэтгэн эрх тэгш, хүндэтгэлтэй хандана;

2.1.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг эрхэмлэсэн ажиллах орчныг бүрдүүлнэ;

2.1.5. олон талт оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлсэн харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэнэ;

2.1.6. ХЗХ-ны нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаална;

2.1.7. ХЗХ-ны нууц болон үйл ажиллагааны хүрээнд олж мэдсэн хувь хүний нууцыг холбогдох хуульд заасны дагуу хамгаална;

2.1.8. ХЗХ-ны гишүүний хувийн болон санхүүгийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана;

2.1.9. ХЗХ-ны гишүүний хувийн болон ажил хэргийн нэр хүндэд аливаа хэлбэрээр халдахгүй байна;

2.1.10. ХЗХ-ны бусдын өмнө хүлээх хариуцлагыг гишүүн нь зөвхөн өөрийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр хариуцна;

2.1.11. ХЗХ-ны гишүүний хүсэлт, санаачилга гаргах, бодлого, дүрэм журам боловсруулах, шийдвэр гаргалтад оролцох оролцоог дэмжинэ;

2.1.12. ХЗХ-ны гишүүнд санхүүгийн үйлчилгээг эелдэг, мэргэжлийн түвшинд үзүүлж, ногдох хувийг тэгш, шударга хуваарилна;

2.1.13. ХЗХ-ны гишүүн, сонгуульт гишүүн, ажилтныг санхүү, эрх зүй болон ёс зүйн мэдлэг олгох, мэдээлэл өгөх сургалтад тогтмол хамруулан мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлнэ;

2.1.14. үндэс, угсаа, хэл, соёл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, улс төрийн харьяалал зэрэг аливаа хэлбэрээр гишүүдийг ялгаварлан гадуурхахгүй байна;

2.1.15. ХЗХ-ны салбарын нэр хүндийг эрхэмлэнэ;

2.1.16. бусад ХЗХ-ны нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараахгүй, харилцан хүндэтгэлтэй хандана;

2.1.17. ХЗХ-ны ач холбогдлыг олон нийтэд таниулах, иргэдийн санхүүгийн суурь мэдлэг, итгэлийг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд бусад оролцогчидтой хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

ГУРАВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СОНГУУЛЬТ ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, АЖИЛТАН, ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

3.1. Сонгуульт гишүүний ёс зүйн хэм хэмжээ:

3.1.1. хууль тогтоомж, ХЗХ-ны дүрэм болон эрх бүхий дээд байгууллагын шийдвэрээр тогтоосон эрх, үүргээ энэхүү дүрэмд заасан ёс зүйн зарчимд бүрэн нийцүүлэх;

3.1.2. ХЗХ-ны дотоод соёлыг хөгжүүлэх;

3.1.3. гишүүдийн эрх ашгийг хангах;

3.1.4. ХЗХ-ны аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй байх;

3.1.5. бусад хүндэтгэлтэй хандах;

3.1.6. дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахгүй, задруулахгүй байх;

3.1.7. эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хичээл зүтгэл гаргаж ажиллах;

3.1.8. аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;

3.1.9. өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх;

3.1.10. сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж, тухайн асуудлаар санал хураалтад оролцохгүй байх;

3.1.11. өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, ажилтны мэдлэг, чадварыг байнга хөгжүүлэх;

3.1.12. энэ дүрмийг зөрчих үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзах ёс зүйтэй байх.

3.2. Гүйцэтгэх захирлын ёс зүйн хэм хэмжээ:

3.2.1. ХЗХ-ны дүрэм, журам, гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлан ХЗХ-ны нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаалах, зохистой удирдах;

3.2.2. үйл ажиллагаагаа шударга, ил тод, нээлттэй байдлаар явуулах;

3.2.3. ажилтны саналыг сонсож, харилцан уялдаа бүхий эргэх холбоотой ажиллах;

3.2.4. ХЗХ-ны нэрийн өмнөөс оролцогчидтой харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

3.2.5. албан үүргээ гүйцэтгэхдээ хамт олонтойгоо эелдэг, тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах;

3.2.6. өөрийн буруутай үйл ажиллагааны хариуцлагыг шударгаар хүлээж, дахин давтахгүй, шаардлагатай тохиолдолд албан тушаалаасаа татгалзах ёс зүйтэй байх;

3.2.7.энэ дүрмийг зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрч, өөрийн болон бусдын алдаа, дутагдлыг илрүүлэн засаж, ажиллахыг эрмэлзэх.

3.3.Ажилтны ёс зүйн хэм хэмжээ:

3.3.1.ХЗХ-ны дүрэм, журам, гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг баримтлан ХЗХ-ны нэр хүнд, өмч хөрөнгийг хамгаалах, ашиглах;

3.3.2.өөрийн мэдлэг, чадварыг байнга хөгжүүлж, үүрэгт ажлаа мэргэжлийн түвшинд үнэнч шударгаар идэвх санаачилгатай, хариуцлагатайгаар гүйцэтгэх.

3.4.Хорооны гишүүний ёс зүйн хэм хэмжээ:

3.4.1.ХЗХ-ны дүрэм, журам, гэрээ, шийдвэрийг чанд сахин биелүүлэх;

3.4.2.хувийн мэдээллээ тухай бүр үнэн зөв, бүрэн мэдэгдэх, шинэчлэх;

3.4.3.ХЗХ-ноос зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, соёлтой, хариуцлагатайгаар оролцох.

3.5. ХЗХ-ны сонгуульд гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх чиглэлээр дараах үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно;

3.5.1.чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөртөө болон нэгдмэл сонирхолтой этгээдэд шууд болон шууд бусаар давуу тал олгох;

3.5.2.ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, сонирхлын зөрчил үүсгэх буюу болзошгүй ажлыг гадуур давхар эрхлэх;

3.5.3.зохицуулагч байгууллагаас явуулж буй бодлого шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд гуйвуулж хүргэх;

3.5.4.ХЗХ болон төрийн эрх бүхий байгууллага, гишүүд, олон нийтийн хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл гаргах;

3.5.5.ХЗХ-ны эд хөрөнгийг хувийн эрх ашигт нийцүүлэн ашиглах;

3.5.6.ХЗХ-ны гишүүдэд хуурамч, буруу ташаа, бүрэн бус мэдээлэл өгч төөрөгдүүлэх, хүнд суртал гаргах;

3.5.7.ХЗХ-нд гишүүн элсүүлэхээр ятгах, шаардах, амлалт өгөх;

3.5.8.ХЗХ-ны гишүүний сонгох болон сонгогдох эрхийг хязгаарлах;

3.5.9.ХЗХ болон түүний гишүүдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх, аливаа этгээдэд ашигтай буюу илт давуу байдал /хөнгөлөлттэй хүү, нөхцөлтэй зээл олгох гэх мэт/ үүсгэх зэрэг ялгавартай байдал бий болгох;

3.5.10.ХЗХ-ны үйл ажиллагааг улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, эрх мэдэлтэн, албан тушаалтнаас хараатаар явуулах;

3.5.11.өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг, урамшуулал зэрэг дараах зүйлс авахыг хориглох бөгөөд аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байна. Үүнд:

3.5.11.а. аливаа хувийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа, түүнтэй холбогдон гарах зардлыг гишүүд эсхүл ХЗХ-ноос авах;

3.5.11.б. аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө гишүүдээс шан харамж авах, өгөх, шаардах;

3.5.11.в. ХЗХ-ны дүрэм болон хууль тогтоомжид нийцээгүй аливаа хураамж, шимтгэл авах;

3.5.11.г. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотойгоор гишүүдээс болон бусдаас мөнгө, бэлэг, эд хөрөнгийн шууд болон шууд бус хэлбэрээр ямар нэг хөнгөлөлт, урамшуулал, үйлчилгээ авах.

ДӨРӨВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1. ХЗХ нь Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, гүйцэтгэх алба болон гишүүдээс бүрдсэн Ёс зүйн зөвлөлийг байгуулна.

4.2. ХЗХ-ны Ёс зүйн зөвлөлөөс өөрийн ХЗХ-ны бодлого, чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг харгалзан мэргэжлийн ёс зүйн дүрмийг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батлах ба хэрэгжилтийг хангах, хариуцлага тооцож ажиллана.

4.3. ХЗХ-ны сонгуульт гишүүн сонгогдох, шинээр ажилтан томилогдох болон гишүүнээр элсэх тухай бүр өөрийн ХЗХ-ны ёс зүйн дүрэм, журамтай танилцаж, зөвшөөрсөн эсэхээ хавсралт дахь баталгааны хуудаст гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Тэргүүлэгчдийн зөвлөлөөс Ёс зүйн зөвлөлийн төсвийг боловсруулан Бүх гишүүдийн хурлаар батлуулна. Хяналтын зөвлөл хүний нөөцийг томилж, шууд харьцана. Тэргүүлэгчдийн зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь холбогдох хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

4.5. ХЗХ-ны ажилтан ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчиж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг Ёс зүйн зөвлөлд/ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

4.6. Ёс зүйн дүрэм зөрчсөн тухай мэдээллийг Ёс зүйн зөвлөл/ажилтан хянаад холбогдох саналыг Хяналтын зөвлөлд хүргүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Тэргүүлэгчдийн зөвлөлд хүргүүлнэ.

4.7. Сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтантай холбоотой ёс зүйн зөрчлийг Хяналтын зөвлөл нь сануулга өгөх, шаардлагатай гэж үзвэл албан тушаалтанд зохих хариуцлага тооцуулахаар эрх бүхий дээд шатны байгууллага болох Тэргүүлэгчдийн зөвлөл, эсхүл Бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

4.8. Ажилтны ёс зүйн зөрчил, хохирлын хэмжээг харгалзан гүйцэтгэх захирлын тушаалаар тухайн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл оногдуулж болно.

4.9. Ёс зүйн дүрэм зөрчиж, зөрчил гаргасан нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

4.10. ХЗХ-ны гишүүн, сонгуульт гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан ёс зүйн зөрчил гаргаж, шийтгэл хүлээсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд зөрчилтэйд тооцно.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ
ЁС ЗҮЙН БАТАЛГААНЫ ХУУДАС

Хадгаламж, зээлийн хоршооны Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүн, Зээлийн хорооны гишүүн, Гүйцэтгэх захирал, ажилтан, ХЗХ-ны гишүүн (аль нь болохыг доогуур нь зурах), ажилтай овогтой би Ёс зүйн дүрмийг уншиж танилцсан бөгөөд дараах зүйлийг баталж байна.

Ёс зүйн дүрэмд заагдсаны дагуу үүрэг хариуцлагаа ухамсарлаж, ёс зүйн хэм, хэмжээг дагаж мөрдөх бөгөөд аливаа ашиг сонирхлын зөрчилтэй, хориглогдсон үйл ажиллагаанд оролцохгүй байх болно.

Огноо: _____

Гарын үсэг: _____ /